



## ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 27 өдөр

Дугаар A/152

Эрдэнэт

### Тамирчдад дэмжлэг үзүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5./а/, 29.2 дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит 4 дүгээр хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2017 оны 03 дугаар сарын 30-наас 4 дүгээр сарын 06-ны өдрүүдэд болох сагсан бөмбөгийн "SPRITE CUP" 16 хүртэлх насны Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох баг тамирчдын оролцооны төлбөр, замын зардлын 995.000 төгрөгийн дэмжлэгийг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах 995.000 /есөн зуун ерэн таван мянга / төгрөгийг Засаг даргын нөөц сан хуваарилагдаагүй бусад зардлын "Соёл, спорт, хүүхэд залуучууд, олон нийтийн арга хэмжээг жилийн туршид зохион байгуулах арга хэмжээний зардал"-аас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын  
24-ны өдрийн дугаар захирамжийн хавсралт



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨСӨВ

№	Утга	Нэгж үнэ	Багийн тоо	Мөнгөн дүн
1	Тамирчдын оролцооны мөнгө	250000	2 баг	500 000
2	Замын зардал	15 000	33 хүн	495 000
3	<b>Нийт үнэ</b>		<b>995 000</b>	

\_000\_